



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 96

Мандалговь

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1 заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


Нэг. Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 11'159'353 /арван нэгэн сая нэг зуун тавин есөн мянга гурван үуун тавин гурав/ төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн хөрөнгийг хавсралтын дагуу “Дундговь-Телевиз” ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд балансаас баланст шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Хөрөнгийг журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга /Д.Доржсүрэн/-д, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж авахыг “Дундговь-Телевиз” ОНӨҮГ-ын дарга /С.Пүрэвсүрэн/ нарт тус тус даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 сарын 30-дрийн 96 дугаар тогтоолын хавсралт



Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад оронон	Тоо хэмжээ	Анхны өртөг	Элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Sony A-1 камер	2012.10.31	1	32'998'890	1'484'950.59	1'814'939.41
2	Камерийн хайрцаг	2012.10.31	1	127'490	57'370.41	70'119.59
3	Edius hard bay	2012.10.31	1	1'869'890	841'450.41	1'028'439.50
4	Дүрсний пульт	2012.09.22	1	2'499'900	1'166'620	1'333'280
5	CG 350 card	2012.10.31	1	3'321'890	1'494'850.41	1'827'039.59
4	Компьютерийн ширээ	2007.12.19	1	40'293	40'293	0
Нийтдүн				11'159'353	5'085'534.82	6'073'818.18